

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛАН,
МЭДЭЭЛЭЛ ГАРГАХ, ХҮРГҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, хууль, эсхүл гэрээний үндсэн дээр төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээд, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл (цаашид "тайлан, мэдээлэл" гэх) гаргах, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхдээ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулна.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. Уг журамд дурьдагдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно.

2.1.1. "тайлан гаргагч" гэж иргэнээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтныг;

2.1.2. уг журамд дурдсан бусад нэр томъёог "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар ойлгоно.

Гурав. Баримтлах зарчим

3.1. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэхэд дараах зарчмыг баримтална.

3.1.1. тайлагнах, мэдээлэх, хүргүүлэх үйл ажиллагаа нээлттэй ил тод байх;

3.1.2. бодит тоо баримт, судалгаа, шинжилгээнд суурилсан нотлогдохуйц байх;

3.1.3. тогтоосон хугацаанд ирүүлсэн байх;

3.1.4. архив, албан хэрэг хөтлөлтийн шаардлагыг бүрэн хангасан байх;

Дөрөв.Тайлан, мэдээллийн шаардлага, бүтэц

4.1.Тайлан, мэдээлэл дор дурдсан шаардлагыг хангасан байна.

- 4.1.1. өмнөх тайлант үеийн тоо мэдээлэлтэй харьцуулагдахуйц байх;
- 4.1.2. өссөн дүнгээр тайлагнасан байх;
- 4.1.3. тайлан, мэдээллийг хуулийн хугацаанд нь хүргүүлсэн байх;
- 4.1.4. байгууллагын дотоод үйл ажиллагаа, хүний нөөцийн асуудлаар гаргасан өргөдлийг тайлан, мэдээлэлд тусгахгүй байх;
- 4.1.5. харьяалах доод шатны байгууллагын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээллийг бүрэн нэгтгэсэн байх.

4.2.Тайлан, мэдээлэл нь дараах агуулгыг багтаасан байна.

- 4.2.1. өргөдөл, гомдлын бүтэц, чиг хандлага;
- 4.2.2. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд хийсэн дүн шинжилгээ;
- 4.2.3. өргөдөл, гомдлын агуулгад хийсэн дүн шинжилгээ;
- 4.2.4. өргөдөл, гомдлын агуулгад хийсэн судалгаа, дүгнэлтэд үндэслэн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн.

4.3. Журмын 4.2.3-т заасан дүн шинжилгээний тайланг 5 дугаар бүлэгт заасан аргачлалын дагуу боловсруулж ирүүлнэ.

4.4. Журмын хавсралтаар баталсан тайлангийн маягтын дагуу тоо мэдээллийг нэгтгэн гаргаж, тайланд хавсаргана.

4.5. Тайлан гаргагч нь иргэнээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах тусгайлсан цахим системийг хөгжүүлэн ажиллаж болох ба цахим системээр хүлээн авсан мэдээлэл нь дүн шинжилгээ хийх боломжтой байхаар системийн бодлогын даалгаврыг боловсруулсан байна.

Тав.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийх

5.1. Өргөдөл, гомдлын тайлангийн дүн шинжилгээг дараах байдлаар ирүүлнэ.

- 5.1.1. дүн шинжилгээний тайланд хуулийн хугацаанд ирүүлсэн, хугацаа хоцроож ирүүлсэн, тайлан мэдээ зөрүүтэй тайлагнасан болон мэдээ ирүүлээгүй нэгжийн мэдээллийг тусгана;
 - 5.1.2. өргөдөл, гомдлыг хууль зүйн үндэслэлтэй шийдвэрлэсэн эсэх, шийдвэрлэлтийн талаар мэдэгдсэн эсэх, мэдэгдсэн хэлбэрийг тусгана;
 - 5.1.3. шийдвэрлээгүй болон хангалтгүй шийдвэрлэлттэй өргөдөл, гомдлын учир шалтгаанд дүн шинжилгээ хийнэ;
 - 5.1.4. 5.1.2. болон 5.1.3.-ын үр дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулна;
- 5.2. Гомдлын агуулгад дүн шинжилгээг хийхдээ дараах зүйлсийг тусгана.

- 5.2.1. салбар, чиглэл бүрээр гаргаж, нийт өргөдөл эзлэх хувийг тооцсон байна;
- 5.2.2. агуулгын хувьд хууль, эрх зүйн орчин, байгууллагын дотоод үйл ажиллагаа, зохион байгуулалт болон төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаа, харилцаа хандлага, мэдлэг ур чадвар эсхүл салбарын онцлогоос хамаарах нөхцөл байдлыг тодорхойлсон байдлаар дүн шинжилгээ хийсэн байна.
- 5.3. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн байдалд шинжилгээ хийж, өмнөх оны мөн үетэй харьцуулан, хамгийн их хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэж буй нэгжийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгсөн байна.
- 5.4. Нийт ирүүлсэн их олонлогоос хамгийн багадаа 5 хувьд түүвэр хийж сэтгэл ханамжийн судалгааг шийдвэрлэлтийн бодит нөхцөл байдал, оновчтой, үр дүнтэй, бодитой шийдвэрлэсэн эсэхэд тухайн ААНБ, иргэдтэй холбогдож тандан судалсан байна.
- 5.5. Байгууллага өргөдөл гомдлыг бууруулах чиглэлээр цаашид анхаарах асуудлын талаар санал боловсруулж ирүүлсэн байна.

Зургаа.Тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх

6.1. Нутгийн захиргааны байгууллага дараах байдлаар тайлан, мэдээлэл гаргаж, хүргүүлнэ.

6.1.1. Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар болон аймаг, нийслэлийн харьяа байгууллага нь журмын 4.2, 4.3, 4.4-т заасан тайлан, мэдээллийг улирал бүрийн сүүлийн сарын 25-наар тасалбар болгож, тухайн сарын 30-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт албан бичгээр хүргүүлнэ.

6.1.2. Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар нь журмын 4.2, 4.3, 4.4-т заасан тайлан, мэдээллийг улирал бүрийн сүүлийн сарын 25-наар тасалбар болгож, сум, дүүрэг, холбогдох агентлаг, байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тайлан, мэдээлэлтэй нэгтгэж 4, 7, 10 дугаар сарын 10, жилийн эцсийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт албан бичгээр хүргүүлнэ.

6.1.3. Хагас, бүтэн жил буюу 7, 1 дүгээр сард гаргах тайланг аймаг, нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хурлын тэмдэглэл, санал дүгнэлтийн хамт Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлнэ.

6.2. Яам, Засгийн газрын агентлаг дараах байдлаар тайлан, мэдээлэл гаргаж, хүргүүлнэ.

6.2.1. Холбогдох агентлаг, байгууллага нь журмын 4.2, 4.3, 4.4-т заасан тайлан, мэдээллийг улирал бүрийн сүүлийн сарын 25-наар тасалбар болгож, тухайн сарын 30-ны дотор яам, сайд, үндэсний хороонд албан бичгээр хүргүүлнэ.

6.2.2. Сайд нь журмын 4.2, 4.3, 4.4-т заасан тайлан, мэдээллийг улирал бүрийн сүүлийн сарын 25-наар тасалбар болгож, холбогдох агентлаг, байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн тайлан, мэдээлэлтэй нэгтгэн 4, 7, 10 дугаар сарын 10, жилийн эцсийн

тайланг дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт албан бичгээр хүргүүлнэ.

6.2.3. Хагас, бүтэн жил буюу 7, 1 дүгээр сард гаргах тайланг сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хурлын тэмдэглэл, санал дүгнэлтийн хамт Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлнэ.

6.3. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах байдлаар тайлан, мэдээлэл гаргаж, хүргүүлнэ.

6.3.1. Төрийн өмчит хуулийн этгээд нь эрхлэх асуудлын хүрээнд журмын 4.4-т заасан тайлан, мэдээллийг улирал бүрийн сүүлийн сарын 25-наар тасалбар болгож, тухайн сарын 30-ны дотор эрхлэх асуудлын хүрээний дээд шатны байгууллагад албан бичгээр хүргүүлнэ.

6.3.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эрхлэх асуудлын хүрээнд журмын 4.4-т заасан тайлан, мэдээллийг улирал бүрийн сүүлийн сарын 25-наар тасалбар болгож, тухайн сарын 30-ны дотор харьяалах аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт албан бичгээр хүргүүлнэ.

6.4. Хууль, эсхүл гэрээний үндсэн дээр төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээд нь уг үүргийн хүрээнд журмын 4.4-т заасан тайлан, мэдээллийг улирал бүрийн сүүлийн сарын 25-наар тасалбар болгож, тухайн сарын 30-ны дотор эрхлэх асуудлын хүрээний дээд шатны байгууллагад албан бичгээр хүргүүлнэ.

6.5. Саналын шинжтэй өргөдлийг хуулиар заагдсан хугацаа /90 хоног/ дуусмагц бусад өргөдөл, гомдлын нэгэн адил энэ журмын 6.1.1 дэх хэсэгт заасан хугацаанд тайлагнах бөгөөд уг өргөдөл, гомдолд дурьдагдсан ажил хэрэгч саналыг холбогдох бодлого шийдвэрт тусгах арга хэмжээг авч, зохион байгуулсан эсэх талаар Засаг даргын болон харьяалах сайдын зөвлөлийн хурлын тэмдэглэлд заавал тусгаж хүргүүлнэ.

Долоо.Хяналт, хариуцлага

7.1. Тайлан, мэдээллийн нотолгоонд суурилсан үнэн зөв байдал, тайлангийн маягтын дагуу гаргасан байдал, заагдсан цагалбарын дагуу зохих байгууллага, албан тушаалтанд хүргэгдэх эсэхийг тайлан гаргагч бүрэн хариуцна.

7.2. Албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас тайлан, мэдээлэл хүргэгдээгүй, хугацаа хоцорсон, буруу тайлагнагдсан тохиолдолд Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу зохих хариуцлагыг тооцно.

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН 20...ОНЫ....УЛИРЛЫН ТАЙЛАН

Байгууллагын нэр	МД	Өргөдөл			Гомдол	Дүн	Хүлээн авсан хэлбэр					Дүн
		Хүсэлт	Санал	Мэдэгдэл			Биечлэн	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр	
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	1											
	2											
	3											
	4											
	5											
	6											
	7											
	8											
Нийт дүн	...											

Балансын шалгалт: Багана5=(1+2+3+4); (5)=(6+7+8+9+10); 5=11;

Мэдээ гаргасан:

.....

/Албан тушаал/

.....

/Нэр/

.....

/Гарын үсэг/

20 оны сарын өдөр

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН 20...ОНЫ...УЛИРЛЫН ТАЙЛАН

Байгууллагын нэр	МД	Өргөдлийн тоо	Өргөдөл (хүсэлт, санал, мэдэгдэл)										МД	Гомдлын тоо	Гомдол									
			Шийдвэрлэсэн					Шийдвэрлэгдээгүй							Шийдвэрлэсэн					Шийдвэрлэгдээгүй				
			Хугацаагаар		Шийдвэрлэлтийн байдлаар			Бусад байгууллагад шилжүүлсэн		Хуулийн хугацаа болоогүй	Шийдвэрлээгүй	Хугацаа			Шийдвэрлэлтийн байдал			Бусад байгууллагад шилжүүлсэн		Хуулийн хугацаа болоогүй	Шийдвэрлээгүй			
			Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн	Хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн	Иргэний талд шийдвэрлэсэн	Хууль, тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй	Тодорхой бус хариу өгсөн	Харьяаллын дагуу шийдэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлсэн тоо	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо			Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн	Хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн	Иргэний талд шийдвэрлэсэн	Хууль, тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй	Тодорхой бус хариу өгсөн	Харьяаллын дагуу шийдэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлсэн тоо	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо						
A	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	Б	11	12	13	14	15	16	17	18	19	20		
	1											1												
	2											2												
	3											3												
	4											4												
	5											5												
	6											6												
	7											7												
	8											8												
Нийт дүн	...											...												

Балансын шалгалт: Багана1=(2+3+7+8+9+10); (2+3)=(4+5+6); 11=(12+13+17+18+19+20); (12+13)=(14+15+16)

Мэдээ гаргасан:
/Албан тушаал/ /Нэр/ /Гарын үсэг/
20 оны сарын өдөр

ГОМДЛЫН АГУУЛГЫН УЛИРЛЫН ТАЙЛАН

Чиглэл	Салбар	МД	Гомдлын тоо	Шийдвэрлэсэн тоо
А	Б	В	1	2
Барилга	Барилга	1		
	Барилгын техникийн хяналтын тухай	2		
	Хот төлөвлөлт	3		
Газар	Газар	4		
Авто зам	Авто зам	5		
	Замын хөдөлгөөн зохицуулалт	6		
Дэд бүтэц, инженерийн байгууламжийн тухай	Дулааны шугам сүлжээ	7		
	Орон сууц, нийтийн аж ахуй	8		
	Цахилгааны шугам сүлжээ	9		
Сууц өмчлөгчдийн холбоодын тухай	Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааны тухай	10		
Нийтийн тээвэр	Нийтийн тээвэр	11		
Төрийн үйлчилгээ, төрийн байгууллагын үйл ажиллагааны тухай	Архив	12		
	Аялал жуулчлал	13		
	Улсын бүртгэл	14		
	Мал эмнэлэг	15		
	Мэдээллийн технологи	16		
	Онцгой байдал	17		
	Цагдаа	18		
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл	19		
	Төрийн үйлчилгээ	20		
	Цэрэг татлагатай холбоотой	21		
	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой	22		
Төрийн албан хаагч	Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой	23		
Нийгмийн хөгжил, нийгмийн хамгааллын тухай	Биеийн тамир, спорт	24		
	Нийгмийн даатгал	25		
	Нийгмийн халамж, үйлчилгээ	26		
	Соёл урлаг	27		
	Хөдөлмөр эрхлэлт	28		
	Хүүхэд гэр бүл	29		
	Эрүүл мэнд	30		
	Дээд боловсролын үйлчилгээний тухай	31		
	Ерөнхий боловсролын үйлчилгээний тухай	32		
	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний тухай	33		
Санхүү, татвар, гаалийн тухай	Төсөв, хөрөнгө оруулалт	34		
	Татварын үйлчилгээний тухай	35		
	Гаалийн үйлчилгээний тухай	36		
Хүрээлэн буй орчин, тохижилт үйлчилгээний тухай	Агаарын бохирдол	37		
	Байгаль хамгаалал	38		
	Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн тохижилт	39		
	Орчны бохирдол, хог хаягдал	40		
Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний тухай	Үйлдвэрлэл	41		
	Хүнс, худалдаа, үйлчилгээ	42		
	Нийт дүн	43		

Мэдээ гаргасан:

.....
/Албан тушаал/.....
/Нэр/

20 оны сарын өдөр

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ЖИШИГ АНГИЛАЛ

д/д	Чиглэл	Салбар	Ангилал
1	Барилга	Барилга	Барилга, байгууламжийн ажлыг зогсоолгох тухай
			Барилгын ажил эхлүүлэх, үргэлжүүлэх зөвшөөрөлтөй эсэхийг шалгуулах тухай
			Шөнийн цагаар барилгын ажил явагдаж байгааг зогсоолгох тухай
			Зөвшөөрөлгүй баригдаж буй барилга, өргөтгөлийг буулгуулах тухай
			Барилгын норм, дүрэм, зөрчигдөж байгаа эсэхийг шалгуулах тухай
			Барилга, байгууламжийн чанар, стандартыг шалгуулах тухай
			Баригдаж байгаа барилгын аюулгүй байдлыг хангуулах тухай
			Барилга байгууламжийн зориулалтыг шалгуулах тухай
			Дахин төлөвлөлтийн барилга баригдахгүй удаашралтай байгаа тухай
			Орон сууц захиалж гэрээ байгуулж төлбөрөө төлсөн боловч хугацаандаа ашиглалтанд ороогүй тухай
			Барилга, байгууламжийн маргаантай асуудлыг шийдвэрлүүлэх тухай
			Барилгын лавлагаа, мэдээлэл, тодорхойлолт хүсэх тухай
			Баригдаж байгаа орон сууцанд давхар захиалга авсан тухай
			Барилгын салбарын тусгай зөвшөөрлийн тухай
		Барилгын техникийн хяналтын тухай	Хот төлөвлөлтийн хяналтын тухай
			Барилгын техникийн хяналтын тухай
			Ус хангамж, ариутгах татуургын хяналтын тухай
			Өргөх байгууламжийн хяналтын тухай
			Барилгын материалын хяналтын тухай
		Хот төлөвлөлт	Гэр хорооллын дахин төлөвлөлтөнд хамрагдах хүсэлтийн тухай
			Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг дахин төлөвлөж барилгажуулах тухай
			Хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хамрагдах тухай
			Барилга, байгууламж, гудамж, талбайн хаяг, хаягжуулалтын тухай
2	Газар	Газар	Газар өмчлөх, эзэмших хүсэлт
			Газрын гэрчилгээ, лавлагаа, мэдээлэл, тодорхойлолт хүсэх тухай
			Газар эзэмших, өмчлөх, шилжүүлэх асуудал шийдвэрлэгдэхгүй удаж байгаа тухай
			Хашаа, хаалт буулгуулах, чөлөөлүүлэх тухай
			Газрын зөрчил арилгуулж, орц, гарц гаргуулах тухай
			Иргэн хоорондын газрын маргааныг шийдвэрлүүлэх тухай
			Албан бичиг, сонсох ажиллагааны мэдэгдлийн хариу, тайлбар
			Газар ашигласны төлбөр төлөхтэй холбоотой
			Газрын үнэлгээтэй санал нийлэхгүй байгаа тухай
			Дуудлага худалдааны анхны үнэ нөхөн төлөхтэй холбоотой
			Чөлөөлсөн газрын нөхөн олговор удаашралтай байгаа тухай
			Газар чөлөөлөх, зөвшилцөх тухай
			E-gazag цахим системийн доголдолтой холбоотой асуудлаар
			Хилийн цэсийн талаар тодруулах тухай
			Нийслэлийн Засаг даргын захирамж хүчингүй болгуулах тухай
			Дүүргийн Засаг даргын захирамж хүчингүй болгуулах тухай
			Газрын гэрээ, гурван талт гэрээний тухай
			Газрын эрхийн маргаан таслах зөвлөлд хандсан тухай
			Газрын ёс зүйн зөвлөлд хандсан
			Авто зам, гүүрийн эвдрэл, гэмтэл их байгаа тухай
			Авто замд сэтгэлгээ хийлгэх орц, гарц гаргуулах тухай
			Авто зам, гүүрийн ажлын төлөвлөлт муу тухай
			Авто зам, гүүрийн ажлын гүйцэтгэл, явц удаашралтай байгаа тухай

3	Авто зам	Авто зам	Авто зам, гүүрийн засвар, үйлчилгээ хийлгэх, хийгдэхгүй удаж байгаа тухай Авто машины зогсоол хүртээмжгүй байгаа тухай Авто машины төлбөртэй зогсоолын төлбөр өндөр байгаа тухай Авто машины төлбөртэй зогсоолын зөвшөөрөлтэй эсэхийг шалгуулах тухай Шалган бүртгэх товчоодын үйл ажиллагааны тухай Авто зам ашигласны төлбөр, хураамж өндөр байгаа тухай Авто замын ус зайлуулах шугам, хоолой стандарт бус байгаа тухай Явган хүний гарцын тухай
		Замын хөдөлгөөн зохицуулалт	Авто замын түгжрэлийг зохицуулуулах тухай Хөдөлгөөнд саад учруулж байгаа автомашинуудыг ачуулах тухай Машин ачилт хийсэн гомдолтой байгаа тухай Замын хөдөлгөөний зөрчил, торгууль шалгуулах тухай Замын хөдөлгөөнд зохицуулалт хийж байгаа цагдаа зохиомол түгжрэл үүсгэж байгаа тухай Гэрлэн дохио ажиллахгүй, эвдрэл гэмтэлтэй, удаж асаж байгаа тухай Замын хөдөлгөөнд оролцож буй жолооч хариуцлагагүй, соёлгүй байгаа тухай Цахилгаан дугуйн хөдөлгөөнд зохицуулалт хийлгэх тухай Хурд сааруулагч стандарт бус, эвдрэл гэмтэлтэй байгаа тухай Хурд сааруулагч шинээр тавиулах тухай Замын тэмдэг, тэмдэглэгээ хийлгэх тухай Орон нутгийн машинаас авч буй төлбөр өндөр байгаа болон түүнийг эсэргүүцэж байгаа тухай Том оврын тээврийн хэрэгсэл хамгаалах хэрэгсэлгүй, цагийн хязгааргүй хөдөлгөөнд оролцож байгаа тухай Жолооны үнэмлэх хэвлэлтийн тухай
4	Дэд бүтэц, инженерийн байгууламжийн тухай	Дулааны шугам сүлжээ	Дулаан хангамжийн төлбөр өндөр байгаа тухай Дулааны шугамын гэмтэл, доголдол их байгаа тухай Дулааны шугамын засвар үйлчилгээний тухай Төвлөрсөн дулаан хангамжийн тухай Дулааны лавлагаа мэдээлэл, тодорхойлолт хүсэх тухай
		Орон сууц, нийтийн аж ахуй	Орон сууцны конторын төлбөр, хураамж өндөр гарч байгаа тухай Хэрэглээний /халуун, хүйтэн/ усан хангамжийн гэмтэл, доголдол, саатлын тухай Орон сууцанд бохир хальж байгаа тухай Цэвэр бохир усны шугам сүлжээнд засвар үйлчилгээ хийлгүүлэх тухай Үзлэгийн худаг, траншейны таг, нүхний тухай Ус алдсан тодорхойлолт авах тухай Тоолуурын заалт буруу бичсэн тухай Ундны ус шаардлага хангахгүй байгааг шийдвэрлүүлэх тухай
5	Сууц өмчлөгчдийн холбоодын тухай	Цахилгааны шугам сүлжээ	Цахилгаан хязгаарлаж байгаа тухай Цахилгааны төлбөр өндөр гарч байгаа тухай Цахилгаан хангамж гэмтэл, доголдолтой байгаа тухай Цахилгааны шугам сүлжээний засвар, үйлчилгээ хийлгүүлэх тухай Цахилгаан лавлах утсаа авахгүй, дуудлаганд ирэхгүй байгаа тухай Төвлөрсөн цахилгаан хангамжид хамрагдах тухай
		Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааны тухай	Байрны гадна талбайн цэвэрлэгээ, тохижилтыг сайжруулах тухай СӨХ-ны үйл ажиллагаанд хяналт тавьж, доголдолтой байдлыг арилгах тухай Байрны подваль, орц, хонгилын цэвэрлэгээ муу байгаа тухай Байрны лифтийн хэвийн үйл ажиллагааг хангуулах, засвар үйлчилгээ тогтмол хийлгэх тухай Орон сууцны дээврийн засвар, арчлалтыг цаг хугацаанд нь хийлгэх тухай СӨХ-ны төлбөр, хураамж, үнэ тарифын тухай

6	Нийтийн тээвэр	Нийтийн тээвэр	Автобусны цагийн хуваарь өөрчлүүлэх тухай
			Автобусны чиглэл, маршрут өөрчлүүлэх, нэмүүлэх тухай
			Шинээр автобусны буудал нэмэгдүүлэх тухай
			Автобусны буудлын тохижилт муу байгаа тухай
			Автобусны цэвэрлэгээ, үйлчилгээ хангалтгүй бохир байгаа тухай
			Автобусны жолооч бэлэн мөнгө авч байгаа тухай
			Автобусны карт уншигч төхөөрөмж эвдрэлтэй, ажиллахгүй байгаа тухай
			Автобусны карт цэнэглэх төхөөрөмж хангалтгүй, дамжин суухад хөнгөлөхгүй байгаа тухай
			Автобусны шалгагчийн үйлчилгээний соёл, харилцаа муу байгаа тухай
			Буудал зарлагч төхөөрөмж ажиллахгүй байгаа тухай
			Нийтийн тээврийн жолооч замын хөдөлгөөний аюулгүй байдал зөрчиж байгаа тухай
			Такси үйлчилгээний тухай
			Олон улсын карго үйлчилгээний тухай
			Автобусны жолоочийн харилцаа, хандлага муу, соёлгүй байгаа тухай
7	Төрийн үйлчилгээ, төрийн байгууллагын үйл ажиллагааны тухай	Архив	Архивын лавлагаа, мэдээлэл хүсэх тухай
			Архивын материал шүүлгэх тухай
		Аялал жуулчлал	Зочид буудлын үйл ажиллагааны тухай
			Гадаадын аялал жуулчлалын тухай
			Дотоодын аялал жуулчлалын тухай
			Аялал жуулчлалын үйл ажиллагааг нэмэгдүүлэх тухай
		Улсын бүртгэл	Иргэний бүртгэлийн тухай
			Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай
			Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай
			Бүртгэлийн лавлагаа, үйлчилгээний тухай
		Мал эмнэлэг	Малын эмчилгээ, үйлчилгээний тухай
			Амьтдын эмчилгээ, үйлчилгээний тухай
			Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай
		Мэдээллийн технологи	Интернет кафе, компьютер тоглоомын газрын үйл ажиллагааны тухай
			Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, зар сурталчилгааны тухай
			E-Service цахим хуудас ажиллахгүй байгаа тухай
		Онцгой байдал	Гал түймрийн аюул, ослын тухай
			Үер, усны аюул, ослын тухай
			Газар хөдлөлийн аюул, ослын тухай
			Хорт бодисын аюул, ослын тухай
			Цасан болон шороон шуургийн аюул, ослын тухай
			Ган, зудны аюул, ослын тухай
			Байгалийн голомтот халдварт өвчний тухай
			Гэнэтийн осол, аваарын тухай
			Нөхөн олговрын тухай
		Цагдаа	Гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлүүлэх тухай
			Гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэхгүй удаж байгаа тухай
		Шүүхийн шийдвэр гүйцэтгэл	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны тухай
			Хорих ангиас чөлөө, тодорхойлолт хүсэх тухай
		Төрийн үйлчилгээ	Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтантай уулзах хүсэлтийн тухай
			Төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагаа
			Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, ажлын албаны үйл ажиллагааны тухай
			Засаг даргын бодлого шийдвэр, үйл ажиллагааны тухай
			Засаг даргын Тамгын газар, ажлын албаны үйл ажиллагааны тухай
			Хороодын үйл ажиллагааны тухай
			Шагнал, урамшууллын тухай

8	Төрийн албан хаагч		Жагсаал цуглаан байгуулах хүсэлт
			Сүм хийдийн үйл ажиллагааны тухай
		Цэрэг татлагатай холбоотой	Цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөгдөх хүсэлтийн тухай
			Цэрэг татлага, оюутан цэрэгт хамрагдах хүсэлтийн тухай
		Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой	Утасны дуудлагад хариу өгөхгүй тухай
			Цагийн хуваарийн дагуу ажиллахгүй байгаа тухай
			Албан бичгийн хариу өгөхгүй тухай
			Өргөдөл, гомдолд хариу өгөхгүй тухай
		Хүний нөөцтэй холбоотой	Ажилд орох тухай
			Цалинтай чөлөө хүсэх тухай
			Цалингүй чөлөө хүсэх тухай
			Ажлаас чөлөөлөгдөх тухай
			Цалин, хөлс хангалтгүй байгаа тухай
			Сургалтанд хамрагдах тухай
			Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай
			Ээлжийн амралт авах тухай
			Жирэмсний амралт авах тухай
			Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай
			Ажлын сахилга, хариуцлага тооцох тухай
			Зэрэг дэв, зэрэг дэвийн нэмэгдлийн тухай
		Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой	Албан хаагчийн мэдлэг, ур чадварын тухай
			Албан хаагчийн харилцаа, хандлагын тухай
			Албан хаагчийн хүнд суртал, ашиг сонирхолын тухай
			Албан хаагчийн дарамт шахалт, ялгаварлан гадуурхалтын тухай
			Хувь хүн, байгууллагын хувийн болон албаны нууцын тухай
			Албан хаагчаас авах үйлчилгээ тодорхойгүй, мэдээллийн ил тод байдалгүй тухай
		Биеийн тамир, спорт	Биеийн тамир, спортын арга хэмжээний тухай
			Фитнес, бялдаржуулах төвүүдийн үйл ажиллагааны тухай
			Биеийн тамир, спортын барилга, байгууламж, газрын тухай
			Биеийн тамир, спортын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн тухай
		Нийгмийн даатгал	Ажилгүйдлийн тэтгэмж орохгүй байгаа тухай
			Илүү төлсөн даатгалын нөхөн олговрын тухай
			Тэтгэврээ дахин шинэчлэн тогтоолгох тухай
			Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын мөнгө авах тухай
			Эмнэлэгт хэвтэн үйлчлүүлсэн хугацааны мөнгө орохгүй байгаа тухай
			Нийгмийн даатгалын систем доголдолтой байгаа тухай
		Нийгмийн халамж, үйлчилгээ	Орон сууц хүсэх тухай
			Ахмадын орон сууцны хөтөлбөрт хамрагдах тухай
			Түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцанд хамрагдах тухай
			Гэр хүсэх тухай
			Мөнгөн тусламж хүсэх тухай
			Сургалтын төлбөр хүсэх тухай
			Эмчилгээний төлбөр хүсэх тухай
			Буцалтгүй тусламж хүсэх тухай
			Хөнгөлөлттэй зээлэнд хамрагдах тухай
			Тэтгэвэр тэтгэмж орохгүй байгаа тухай
			Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоолгох тухай
			Хүүхэд үрчлэх тухай
			Ахмадын асрамжийн төвд асруулах тухай
			Урлаг соёлын арга хэмжээний тухай

9	Нийгмийн хөгжил, нийгмийн хамгааллын тухай	Соёл урлаг	Соёл, урлагийн байгууллагын барилга, байгууламж, газрын тухай
			Соёл, урлагийн байгууллагын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл дутмаг байгаа тухай
		Хөдөлмөр эрхлэлт	Гадаад иргэний хөдөлмөр эрхлэлтийн тухай
			Хууль бус хөдөлмөр эрхлэлтийн тухай
			Ажлын байр нэмэгдүүлэх, жижиг зээлд хамруулж өгөх тухай
			Жижиг дунд үйлдвэрийг дэмжих, хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлтийн тухай
			Хувиараа, нөхөрлөл, хоршоогоор хөдөлмөр эрхлэгч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд санхүүгийн дэмжлэг олгох тухай
			Хөдөлмөрийн харилцаа, маргааны тухай
			Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн тухай
		Хүүхэд гэр бүл	Хүүхдийн зусланд амраах тухай
			Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны тухай
			Гэр бүлийн хүчирхийллийн тухай
			Хүүхдийн эрхийг хамгаалуулах тухай
		Эрүүл мэнд	Эмнэлэгт үзлэг, шинжилгээний цаг авахад хүндрэлтэй байгаа тухай
			Эмч, ажилчдын эмчилгээ үйлчилгээ хангалтгүй байгаа тухай
			Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөц дутмаг байгаа тухай
			Эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл дутмаг байгаа тухай
			Эмнэлгийн ор, үзлэгийн хэрэгсэл, хангамж муу байгаа тухай
			Эрүүл мэндийн байгууллагын барилга, байгууламж, газрын тухай
			Эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтны цалин, хөлс, тэтгэмж бага байгаа тухай
			Эмийн сангийн үйлчилгээний тухай
			Эмийг олгох нөхцөл /жортой, жоргүй/-тэй холбоотой
			Эм, тарианы бүртгэл, хүртээмж, тасалдал, эмийн үнийн тухай
			Их, дээд сургуулийн элсэлт, бүртгэлийн тухай
		Дээд боловсролын үйлчилгээний тухай	Гадаад улсад суралцах тухай
			Оюутны зээл, тусламж, дэмжлэгийн тухай
			Элсэлтийн ерөнхий шалгалтын тухай
			Сургалтын төлбөр буцаах тухай
			Сургалтын хөтөлбөр, нэгж хичээлийн тухай
			Их, дээд сургуулийн хүний нөөц дутмаг байгаа тухай
			Их, дээд сургуулийн багш ажилтны цалин, хөлс, тэтгэмж хангалтгүй байгаа тухай
			Их, дээд сургуулийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл дутмаг байгаа тухай
		Ерөнхий боловсролын үйлчилгээний тухай	Сургуулийн элсэлт, бүртгэлийн тухай
			Сургууль хууль бусаар төлбөр хураамж, хандивын мөнгө хурааж байгаа тухай
			Сургуулийн автобус үйлчилгээ хүртээмжгүй байгаа тухай
			Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ шим тэжээлгүй муу байгаа тухай
			Сургуулийн анги танхим, орчны аюулгүй байдлын тухай
			Дүрэмт хувцас, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний тухай
			Сургалтын хөтөлбөр, нэгж хичээлийн тухай
			Сургуулийн барилга, байгууламж, газар, хөрөнгө оруулалтын тухай
			Сургуулийн хамран сургах тойргийн тухай
			Суралцагчийн сурах эрхийг хангах, хамгаалах тухай
			Сургуулийн цэвэрлэгээ, халдвар хамгаалал, ариутгал муу байгаа тухай
			Сургуулийн хүний нөөц дутмаг байгаа тухай
			Сургуулийн багш ажилтны цалин, хөлс, тэтгэмж хангалтгүй байгаа тухай
			Сургуулийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл дутмаг байгаа тухай
			Цэцэрлэгийн элсэлт, бүртгэлийн тухай
			Цэцэрлэгийн хууль бус төлбөр хураамж, хандивын мөнгө, мөнгө хураалтын тухай

		Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний тухай	Цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ шим тэжээлгүй муу байгаа тухай
			Цэцэрлэгийн анги танхим, орчны аюулгүй байдлын тухай
			Цэцэрлэгийн цэвэрлэгээ, халдвар хамгаалал, ариутгал муу байгаа тухай
			Цэцэрлэгийн хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн дутмаг байгаа тухай
			Цэцэрлэгийн сургалтын хөтөлбөр, нэгж хичээлийн тухай
			Цэцэрлэгийн барилга, байгууламж, газар, хөрөнгө оруулалтын тухай
			Цэцэрлэгийн хамран сургах тойргийн тухай
			Суралцагчийн сурах эрхийг хангах, хамгаалах тухай
			Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш ажилтны цалин, хөлс, тэтгэмж бага байгаа тухай
			Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүний нөөц дутмаг байгаа тухай
			Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл дутмаг байгаа тухай
10	Санхүү, татвар, гаалийн тухай	Төсөв, хөрөнгө оруулалт	Төсөв, хөрөнгө оруулалтын тухай
			Төлбөрийн баримт олгохгүй тухай
		Нэмэгдсэн өртгийн албан татварын цахим системийн тухай	ААН илгээгээгүй/ үнийн дүн зөрүүтэй тухай
			Борлуулагч баталгаажуулаагүй тухай
			Кассын машин эвдэрсэн/ сүлжээ тасарсан тухай
			И-мэйл хаягаар ирүүлнэ гэсэн боловч ирүүлээгүй тухай
			Хямдарсан бараанд НӨАТ өгөхгүй тухай
			И-баримтын бүртгэл, устгуулах, мэдээлэл засуулах тухай
			Буцаан олголтын тухай
			Өндөр дүнтэй төлбөрийн баримт бүртгэгдэхгүй, НӨАТ-ын урамшуулал нь орж ирэхгүй байгаа тухай
		Татварын үйлчилгээний тухай	Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлж чадаагүй, тайлан буцсан, тайлан засварлах, хялбаршуулсан горимоор тайлан илгээх, эрх нээлгэх тухай
			Татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой
			Онцгой албан татварын тэмдгийн зөрчлийн тухай
			Татварын хяналт шалгалт хийлгэх тухай
		Гаалийн үйлчилгээний тухай	Үнэ, үнэлгээний маргааны тухай
			Гаалийн татварын тухай
			Бүрдүүлэлтийн дараах шалгалтын дүгнэлтэд гомдол гаргах тухай
			Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн тухай
			Гаалийн зөрчлийн тухай
11	Хүрээлэн буй орчин, тохижилт үйлчилгээний тухай	Агаарын бохирдол	Агаарын бохирдлын тухай
			Агаарын бохирдлын хэмжилт хийлгэх тухай
			Шахмал болон боловсруулсан түлшний чанарт хяналт тавьж, стандарт мөрдүүлэх тухай
		Байгаль хамгаалал	Ойн ашиглалт, хамгаалалтын тухай
			Гол горхи, худаг усны ашиглалт, хамгаалалтын тухай
			Ногоон бүсийн ашиглалт, хамгаалалтын тухай
			Байгалийн нөөц ашиглалт, хамгаалалтын тухай
			Хөрсний бохирдлын тухай
			Усны бохирдлын тухай
			Байгаль орчинд хохирол учруулж байгаа тухай
		Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн тохижилт	Явган хүний зам, талбайн тохижилтыг сайжруулах тухай
			Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн цэвэрлэгээ хангалтгүй байгаа тухай
			Ногоон байгууламжийн тохижилт, хамгаалалтын тухай
			Нийтийн бие засах газар хүрэлцээгүй байгаа тухай
			Гэрэлтүүлэг, чимэглэлийн тухай
			Зар сурталчилгаа, мэдээллийг самбаруудыг зохицуулах, шаардлага хангахгүй самбаруудыг цэгцлэх тухай

12	Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний тухай	Орчны бохирдол, хог хаягдал	Хөшөө, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах, арчилгаа үйлчилгээ хийлгэх тухай
			Хог цэвэрлэгээ, тээвэрлэлт хугацаандаа хийгдэхгүй байгаа тухай
			Хог тээвэрлэлтийн үнэ тарифын тухай
			Хогийн сав, хогны бункер нэмүүлэх, байршил өөрчлүүлэх тухай
			Золбин нохой, муур устгуулах тухай
			Хальтаргаа, гулгааг арилгах, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийлгэх тухай
			Орчны эвгүй үнэр, бохирдлын тухай
			Барилга хог хаягдлын ангилал, устгалын тухай
			Эмнэлгийн хог хаягдлын ангилал, устгалын тухай
	Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний тухай	Үйлдвэрлэл	Жижиг, дунд үйлдвэрлэлийн тухай
			Олон улсын үзэсгэлэнд оролцох тухай
			Төсөл, хөтөлбөрт хамрагдах тухай
		Хүнс, худалдаа, үйлчилгээ	Орон сууцны 1-р давхарт байрлах үйлчилгээний газруудад хяналт тавих тухай
			Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн болон ТҮЦ, павильоны тухай
			Ил задгай худалдаа, үйлчилгээний тухай
			Зах болон худалдааны төв, дэлгүүрийн худалдаа, үйлчилгээнд хяналт тавих тухай
			Согтууруулах ундааны зөвшөөрөл, худалдаа үйлчилгээнд хяналт тавих тухай
			Тамхины зөвшөөрөл, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих тухай
			Хоолны газар, баар, рестораны үйл ажиллагаанд стандарт мөрдүүлэх тухай
			Түлээ, нүүрсний борлуулалтын цэг, түгээлт хангалтгүй байгаа тухай